

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ, ЗАХИРГААНЫ  
ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ  
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦЭХ  
ЭСЭХ ТАЛААР ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРСАН  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 04 дүгээр  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
З.Баянсэлэнгэ**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, М.Батчимэг, Ж.Батсуурь, Д.Батцогт, Ц.Даваасүрэн, Д.Сарангэрэл, Г.Уянга, Х.Тэмүүжин нарын 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2015 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Манай улсад тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд эрчимтэй өсч, 2014 оны байдлаар улсын хэмжээнд бүртгэлтэй 674.869 автомашины 61.7 хувь буюу 416.360 автомашин нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэлтэй байгаа нь замын хөдөлгөөний ачаалал нэмэгдэж, хөдөлгөөний эрчим суларч, түгжрэл саатал үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Монгол Улсын хэмжээнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2143 бүртгэгдсэний 1080 буюу 49,6 хувь нь орон нутагт, 1063 буюу 50,4 хувь нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдэж, 2013 онтой харьцуулахад гэмт хэрэг 0,2 хувиар, нийслэлд 12,2 хувиар тус тус буурч, орон нутагт 15,9 хувиар өссөн байна.

Нийслэлд 27.852 зам тээврийн осол бүртгэгдсэнээс 23.054 буюу 82,8 хувь нь эд материалын хохиролтой 17.2 хувь нь хүн гэмтсэн, хүний амь нас, эрүүл мэнд тодорхой хэмжээгээр хохирсон байна. Судалгаагаар 18-40 насны эрэгтэй хүмүүс нь зам тээврийн осолд өртөж нас барж, гэмтэж байгаа нь энэ насны хүмүүс замын хөдөлгөөнд идэвхтэй оролцдогтой холбоотой байна.

Хууль санаачлагчид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэх, замын хөдөлгөөний зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрийн бодлого, зохицуулалтыг шинэ түвшинд хүргэх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үзэл баримтлалын томоохон шинэчлэлийг төсөлд тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан зам тээврийн гэмт хэрэг зөрчлийн статистик тоо, баримтыг 10-20 жилээр гаргаж байх, явган хүний болон хөгжлийн бэрхшээлтэй хүний замын асуудал, бүрэн бус тээврийн хэрэгсэл, хамгаалах бүсний асуудлыг олон улсын стандартад нийцүүлэх заалтыг төсөлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ автомашины дугуй түгжих, тээврийн хэрэгслийг ачих асуудлыг хуулийн төсөлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ зам, замын байгууламжийн төлөвлөлт, зохион байгуулалтыг хуулийн төсөлд тусгах, жолооч бэлтгэх сургалтын чанарыг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар мэргэжлийн замын цагдаагийн алба хаагчийг бэлтгэхэд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан найрсаг Улаанбаатар хөтөлбөрийг төрийн байгууллага дэмжиж ажиллах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй, ядарсан болон мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн эсэхийг тогтоохыг хуулийн төсөлд нарийвчлан тусгах зэрэг саналыг гаргаж байсан болно.

Уг хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.


Түүнчлэн тус Байнгын хорооноос дээрх хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллуулах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Д. ГАНБАТ